



## АРЬС СУДЛАЛ

АХЛАХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шалгуурыг хангасан байна. Үүнд:

1. Сургалт эрхэлсэн байгууллагаас зохион байгуулсан мэргэшил дээшлүүлэх сургалт болон гадаад оронд сургалтын эрх, зөвшөөрөлтэй байгууллагад 1 сараас дээш хугацаагаар мэргэшил дээшлүүлсэн байх /хамгийн багадаа 12 багц цаг биелүүлсэн байх/
2. Арьс судлалын чиглэлээрх мэргэжил арга зүйн бодлогын баримт, бичиг боловсруулах ажлын хэсэгт дангаар болон багаар оролцсон эсвэл санал өгсөн байх – 1
3. Судалгаа шинжилгээний ажил: Илтгэл, өгүүлэл мэргэжлийн хурал, зөвлөгөөн, сэтгүүлд хэлэлцүүлсэн / хэвлүүлсэн - 5

ТЭРГҮҮЛЭХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шалгуурыг хангасан байна. Үүнд:

1. Ахлах зэрэг хамгаалснаас хойш 5 жил мэргэжлээрээ ажилласан
2. Сургалт эрхэлсэн байгууллагаас зохион байгуулсан мэргэшил дээшлүүлэх сургалт болон гадаад оронд сургалтын эрх, зөвшөөрөлтэй байгууллагад 1 сараас дээш хугацаагаар мэргэшил дээшлүүлсэн байх /хамгийн багадаа 12 багц цаг биелүүлсэн байх/
3. Өөрийн байгууллагын залуу эмч, резидент эмч болон оюутан нарт багшилсан, иргэдэд өвчнөөс урдчилан сэргийлэх, эрүүл амьдрах ухааны талаар сургалт зохион байгуулсан /12 болон түүнээс дээш цаг/
4. Мэргэшлийн чиглэлээр зохион байгуулсан багц цагийн богино хугацааны сургалт удирдсан байх /3 ба түүнээс дээш удаа/
5. Арьс судлалын чиглэлээрх мэргэжил арга зүйн бодлогын баримт, бичиг боловсруулах ажлын хэсэгт дангаар болон багаар оролцсон эсвэл санал өгсөн байх /5 болон түүнээс дээш/
6. Судалгаа шинжилгээний ажил: Илтгэл, өгүүлэл мэргэжлийн хурал, зөвлөгөөн, сэтгүүлд дотоод -5, гадаадын - 1 хэвлэж /хэлэлцүүлсэн байх

ЗӨВЛӨХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шалгуурыг хангасан байна. Үүнд:

1. Тэргүүлэх зэрэг хамгаалснаас хойш 5 жил мэргэжлээрээ ажилласан
2. Сургалт эрхэлсэн байгууллагаас зохион байгуулсан мэргэшил дээшлүүлэх сургалт болон гадаад оронд сургалтын эрх, зөвшөөрөлтэй байгууллагад 1 сараас дээш хугацаагаар мэргэшил дээшлүүлсэн байх /хамгийн багадаа 12 багц цаг биелүүлсэн байх/
3. Судалгаа шинжилгээний ажил: ном товхимол бичсэн байх, Илтгэл, өгүүлэл гадаадад – 3 түүнээс дээш хэвлэж /хэлэлцүүлсэн байх
4. Арьс судлалын чиглэлээрх мэргэжил арга зүйн бодлогын баримт, бичиг боловсруулах, батлуулахад 10-с дээш удаа оролцсон байх.